# БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
# "БЭРХ БИШ ЭЭЛТЭЙ" АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2021 оны 12 дугаар сарын 10 — Багануур дүүрэг

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Гүйцэтгэл | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1. | Байгууллагын ажилтнуудын дунд хөгжлийн бэрхшээлийг даван туулж, нийгэмд өв тэгш хамрагдаж байгаа хүмүүсийн жишээ болон ХБИ-д тулгамддаг асуудлуудын талаар чөлөөт хэлэлцүүлэг зохион байгуулах | Зохион байгуулах тоо | 1 | – 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр байгууллагын ажилтнуудын дунд хөгжлийн бэрхшээлийг даван туулж, нийгэмд өв тэгш хамрагдаж байгаа болон хувиараа хөдөлмөр эрхлэдэг хүмүүсийн мэдээлэл, ХБИ-д тулгамддаг асуудлуудын талаар чөлөөт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.<br><br>– Тус хэлэлцүүлгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй албан хаагч маань Багануур дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд өгөх сургалт, арга зүй дутмаг, мөн хүүхэд талаас нь орчин нөхцөлийн сайжралтад анхаарах, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа шалтгааныг бууруулах, олдмол хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өргөн хүрээтэй зохион байгуулах, харилцаа хандлага талаас анхаарах хэрэгцээ шаардлагатай гэж харж байгаагаа онцолсон юм.<br>– Дээрх асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Бодлогын хэрэгжилтийн газарт албан бичгээр уламжилсан. | "Үр дүнтэй"-100% |
| 2. | Байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагчийн ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хууль эрх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | – Манай байгууллагын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1 ажилтантай. Тайлант оны хугацаанд цар тахалтай холбогдон гарсан тогтоол шийдвэрийн хүрээнд шаардлагатай тохиолдолд тус ажилтанг гэрээсээ цахимаар ажиллах нөхцөлөөр ханган ажилласан.<br>– 2021 оны 12 дугаар сарын 03-нд буюу Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих Олон улсын өдрийг тохиолдуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн талаарх үндсэн ойлголт, Монгол Улсын хэмжээнд | "Үр дүнтэй"-100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зүйн талаас зөвлөмж мэдээлэл өгөх | | | ХБИ-д үзүүлж буй тусламж үйлчилгээ, нийгэм хамгааллын талаарх мэдээллийг албан хаагчдад хүргэж ажилласан. | |
| 3. | Бэрх биш Ээлтэй аяны хүрээнд тавигдах постер, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэлд бүтээгдэхүүн, ээлтэй орчны талаарх мэдээлэл зэргийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан түгээх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | “Бэрх биш Ээлтэй” фейсбүүк хуудсанд тавигдсан мэдээллээс багцлан байгууллагын цахимаар хуудсаар дамжуулан олон нийтэд түгээсэн.<br>Байршуулсан мэдээллийн тоо – 10<br>Мэдээллийг уншсан тоо – 38<br> | “Үр дүнтэй”- 100% |

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
КЛАСТЕР ИНЖЕНЕР Э.ЭНХЗАЯА